

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудитор Ундэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН



Бүс нутгийн хөгжлийг дэмжсэн бодит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна

Аудитыг гүйцэтгэсэн:
**YAG-ын Гүйцэтгэлийн аудитын
Газар**

Захирал: Б.Баттуяа

 Хэлтсийн захирал,
менежер: Г.Гүнжидмаа

 Нэгдүгээр хэлтсийн
Ахлах аудитор Л.Эрдэнэчулуун

 Аудитор Л.Авирмэд
С.Одонцэцэг

Туслах аудитор Г.Батсүх

*Аудитын дүн, дүгнэлт,
зөвлөмжтэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах
асууж лавлах, холбогдох
саналаа өгөхийг хүсвэл
263755, 261805 дугаарын
утас, 323266 дугаарын
факсаар харилцана уу.*

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160

МОНГОЛ УЛС
АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл	3
Бүлэг 1. Тогтвортой байдлын гэрээний дагуу хийгдсэн гэх хөрөнгө оруулалтад баталгаажилт хийгдээгүй байна	
Оршил	4
▪ Тогтвортой байдлын гэрээг тухайн үеийн хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн байна	4
▪ Гэрээнд оруулсан зарим нэмэлт, өөрчлөлт тухайн компанид давуу байдлыг бий болгосон байна	6
▪ Хөрөнгө оруулалт хуваарийн дагуу хийгдсэн гэх боловч баталгаажуулалт болон хяналт хангалтгүй байна	7
▪ Сангийн яам гэрээний хэрэгжилт, гэрээ дуусвар болж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, цаашид хэрхэх талаар тодорхой бодлогогүй байна	9
▪ Бүс, орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалтын зарим ажлын талаар	10
Бүлэг 2. Гэрээтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байна	
▪ Монгол Улсын хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна	12
▪ “Төмөртийн Овоо”-ны ордын нөөцөд тогтоогдсон дагалдагч металлыг үнэлээгүй байна	13
▪ Бороогийн ордын нийт баялгийг бүрэн ашиглах төлөвлөгөөгүй байна	16
Дүгнэлт	18
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:	
1. Сангийн яамнаас ирүүлсэн санал	19
2. Уул уурайн яамнаас ирүүлсэн санал	22
Саналд өгсөн тайлбар:	
Сангийн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар	24
Уул уурхайн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар ...	24
Зөвлөмж	25
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	26

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМГ	Ашигт малтмалын газар
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМО	Ашигт малтмалын орд
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БОНБНҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГХОЗБГ	ЭЗХЯ-ны Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар
ГХОТХ	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТБГ	Тогтвортой байдлын гэрээ
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УААА	Улс ардын аж ахуй
УБУ	Уулын баяжуулах үйлдвэр
УИХ	Улсын Их Хурал
УОНТ	Улс, орон нутгийн төсөв
УУЯ	Уул уурхайн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудитор Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Тогтвортой байдлын гэрээний хэрэгжилт, үр дүнгийн байдлыг дараах дэд зорилтын хүрээнд шалган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Үүнд:

- *Тогтвортой байдлын гэрээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд харилцан ашигтай, оновчтой хийгдсэн эсэх,*
- *Тогтвортой байдлын гэрээний биелэлт, гүйцэтгэлийг хугацаанд нь үнэн зөв тайлагнах, үр дүнг тооцох, хэрэгжилтийг үнэлэх үр нөлөөтэй хяналтын тогтолцоо үйлчилж буй эсэх.*

Хамарсан хүрээ

Аудитад Сангийн яам, УУЯ, БОНХЯ, АМГ, ТЕГ, ГЕГ, МХЕГ, тогтвортой байдлын гэрээтэй ажиллаж буй Цайрт минерал, Бороогоулд, Востокнефтгаз, Эрин интернэшл, Чин Хуа-Мак-Нарийн сухайт, Суруга Монгол ХХК хамрагдав.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан “Тогтвортой байдлын гэрээ”-ний хэрэгжилтийг холбогдох байгууллагын удирдлага, албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, холбоотой талуудын тайлан, баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу аудитын дүнд дэмжлэг болох нотлох зүйл цуглуулж, судлан тайлан бэлтгэв.

ТБГ-тэй ААН-үүдийн санхүү, үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааг аудитад бүхэлд нь хамруулаагүй бөгөөд баримт материалаас сонголт хийн ашиглахын зэрэгцээ тоон үзүүлэлтэд суурилан дүн шинжилгээ, харьцуулалт хийх, гэрээнд заасан хуваарийн дагуу хийгдэх хөрөнгө оруулалтыг судлах, танилцах, бүтээгдэхүүний өртөг, зардлын судалгаа хийх, орон нутгийн зарим төрийн байгууллагын төлөөлөлтэй ярилцлага хийн санал, сэтгэгдлийг хүлээн авч ажиллав.

ТБГ байгуулсан талуудын хооронд харилцсан албан бичиг, мэргэжлийн байгууллагаас гаргасан судалгаа дүгнэлтийг судлан үзэх, цахим хуудсаар илэрхийлэгдсэн уул уурхайн болон эрдэс баялгийн үнийн мэдээллийг судалж үзэв.

Аудитын явцад ҮСХ, ЭЗХЯ-ны Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар, Хөдөлмөрийн яам, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх болон Нийслэлийн өмчийн харилцааны газар зэрэг газруудаас нэмэлт лавлагаа, тоон мэдээлэл авч судалгаанд ашиглав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1. Тогтвортой байдлын гэрээний дагуу хийгдсэн гэх хөрөнгө оруулалтад баталгаажилт хийгдээгүй байна

Оршил

Сангийн яам гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2³, Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйл⁴, “Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2⁵ зэрэг заалтуудыг удирдлага болгон Засгийн газрын 1997 оны 226, 2002 оны 46, 2005 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Тогтвортой байдлын гэрээ”-ний загварыг мөрдөж гэрээ байгуулжээ.

Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан “Тогтвортой байдлын гэрээ” /цаашид “ТБГ” гэх/ нь хүчин төгөлдөр байх хугацаанд түүнийг байгуулснаас хойш батлагдсан татварын хууль тогтоомжийн өөрчлөлтөөс үл хамаарах баталгаа болж байна.

Тогтвортой байдлын гэрээг тухайн үеийн хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн байна

1.1 Тогтвортой байдлын гэрээ байгуулах хууль эрх зүйн үндэслэлүүд:

- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйл “Тогтвортой байдлын гэрээ”, 20 дугаар зүйл “Тогтвортой байдлын гэрээ байгуулах”,
- Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйл “Татвар бий болгох, өөрчлөх, чөлөөлөх, хүчингүй болгох”,
- Ашигт малтмалын тухай хуулийн (1997 оны) 20 дугаар зүйл “Тогтвортой байдлын гэрээ”, 21 дүгээр зүйл “Тогтвортой байдлын гэрээ байгуулах”,
- Хуульд заасан үндэслэлийн дагуу Засгийн газраас баталсан “Тогтвортой байдлын гэрээний загвар батлах тухай” 3 удаагийн тогтоол зэрэг болно.

1.2 2012 оны байдлаар Монгол Улсын Засгийн газартай “Тогтвортой байдлын гэрээ” байгуулсан гадаадын хөрөнгө оруулалттай 6 хуулийн этгээд эдийн засаг, үйлдвэрлэл үйлчилгээний 6 өөр салбарт үйл ажиллагаа явуулж байна.

1.3 Холбогдох хуульд заасанчлан татварын орчин, хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацааг тогтоон Засгийн газрын тогтоолоор баталсан загварын дагуу Сангийн яам ТБГ-г тухайн хуулийн этгээдтэй байгуулсан байна.

¹ Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шинэчилсэн найруулгын 29.1 дүгээр зүйл,

² Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1 дүгээр зүйл

³ 19.2. Тогтвортой байдлын гэрээний загварыг Монгол Улсын Засгийн газар батална. Энэхүү гэрээний загвар нь тодорхой хугацаанд татварын тогтвортой нөхцөлийг хангах бөгөөд тухайн хөрөнгө оруулалтын зорилго, хэмжээ, гэрээг цуцлах үндэслэл, хэрэгжүүлэх хугацааны тухай нөхцөлийг агуулсан байна.

⁴ 20 дугаар зүйл. Тогтвортой байдлын гэрээ

⁵ “хууль тогтоомжоор олгосон эрхийн хэмжээ, хязгаарт багтаан Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын, эсхүл хөрөнгө оруулалтын гэрээгээр уг гэрээг байгуулах үед мөрдөгдөж байсан татварын нөхцөлийг хадгалах дэглэм тогтоох”

1.4 ЭЗХЯ-ны ГХОЗБГ-аас ирүүлсэн мэдээлэлд дурдсанаар дээрх 6 ААН-ийн гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний хүчинтэй байх хугацаа 2014-2024 он хүртэл үргэлжлэх ба эдгээрээс Востокнефтегаз, Чин Хуа-Мак-Нарийн сухайт, Эрин интернэшнл ХХК-ийн хугацаа 2014 онд дуусахаар байна.

Хүснэгт №1

Хуулийн этгээдийн нэр	Өмчийн хэлбэр	Хөрөнгө оруулагчийн нэр	Хөрөнгө оруулагчийн төрөл	Хувь	ХНХ-ийн хэмжээ /ам.долл/	Улс
Бороогоулд ХХК	Гадаад улсын	Centerra Netherlands B.V Co.,Ltd	Хуулийн этгээд	100%	1 000 000	Нидерланд
Суруга Монгол ХХК	Гадаад улсын	Suruga corporation	Хуулийн этгээд	100%	43 700 000	Япон
Востокнефтегаз ХХК	Гадаад улсын	Corporate Prestige Limited	Хуулийн этгээд	100%	100 000	Виржини арлууд (УК)
Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК	Хувийн /Хамтарсан/	Чин Хуа ХХК	Хуулийн этгээд	50%	14 502 720	БНХАУ
		Б.Нямтайшир	Хувь хүн	50%	14 502 669	Монгол
Эрин-Интернэшнл ХХК	Хувийн /Хамтарсан/	Д.Цэрэннадмид	Хувь хүн	3.8%	109 472	Монгол
		Я.Эрхэмбаяр	Хувь хүн	4.8%	138 145	Монгол
		Д.Дэрин	Хувь хүн	3.8%	109 472	Монгол
		Дайнем Инвестмент ХХК	Хуулийн этгээд	87.5%	2 500 000	Япон
Цайрт минерал ХХК	Хувийн /Хамтарсан/	БНХАУ-ын Өнгөт төмөрлөгийн гадаад барилга, зураг төслийн компани	Хуулийн этгээд	50%	50 000	БНХАУ
		Металимпекс ХХК	Хуулийн этгээд	50%	50 000	Монгол

1.5 Мэдээллээс үзэхэд ААН-үүдийн хөрөнгө оруулагч, хувь нийлүүлсэн хөрөнгийн дийлэнх хувийг гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулагчид эзэлж байгаа бөгөөд дотоодын ААН байхгүй байна.

1.6 Харин эдгээр ААН-үүдээс Бороогоулд, Востокнефтегаз ХХК-ийн гол хөрөнгө оруулагч хуулийн этгээд нь “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”-тэй улс орнуудад бүртгэлтэй байна.

1.7 ТБГ-ний хүчинтэй хугацаа, оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг харуулбал:

Хүснэгт №2

№	ААН-ийн нэр	Гэрээний хугацаа			Хөрөнгө оруулалтын хэмжээ /сая ам.долл/	Үйл ажиллагааны хүрээ
		Эхэлсэн	Дуусах	жил		
1	Цайрт минерал ХХК	1998.05.15	2013.05.15	15	21.0	<i>Цайрын ордыг үйлдвэрлэлийн аргаар эзэмших, ашиглах</i>
		2007.08.23				
2	Бороогоулд ХХК	1998.07.06	2008.07.06	10	15.0	<i>Алтны үндсэн ордыг эзэмших, ашиглах, экспорт</i>
		2000.05.09	2013.07.07	15	25.0	
		2007.08.03				
3	Востокнефтегаз ХХК	2002.03.26	2017.03.26	15	50.0	<i>Шатдаг хий, нефть боловсруулах үйлдвэр барих, үйл ажиллагаа явуулах</i>
		2005.09.08	2020.09.08	15	300.0	
		2005.12.16				
4	Эрин Интернэшнл ХХК	2005.01.17	2015.01.17	10	4.0	<i>Гаалийн тусгай бүс байгуулах, ажиллуулах</i>

5	Чин Хуа-МАК-Нарийн сухайт ХХК	2005.07.04	2015.07.04	10	5.3	Чулуун нүүрс хайгуул олборлолт, экспорт
6	Суруга Монгол ХХК	2007.07.27	2022.07.27	15	100.0	Бетон зуурмагийн үйлдвэрлэл, барилга

Гэрээнд оруулсан зарим нэмэлт, өөрчлөлт тухайн компанид давуу байдлыг бий болгосон байна

1.8 Цайрт минерал ХХК-тай байгуулсан гэрээнд 1 удаа, Бороогоулд ХХК-ийн гэрээнд 2 удаа, Востокнефтегаз ХХК-ийн гэрээнд 2 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

1.9 Ингэхдээ гэрээнд алдаатай тусгагдсан зүйл заалтыг өөрчлөх, гэрээлэгч талын хүсэлт санаачлага, мөн “Дэлхийн зах зээл дээрх үнэт металлын үнийн өсөлт, нийгэмд үүсч буй болон байгуулсан гэрээ нь өнөөгийн нөхцөл байдалд нийцэхгүй болсон” зэрэг үндэслэл, шаардлагыг талууд харилцан тохиролцож тодотгосон гэж дурдсан байна.

1.10 Гэвч гэрээнд оруулсан зарим нэг нэмэлт, өөрчлөлт талуудын тэгш, харилцан ашигтай байдлыг алдагдуулсан, зөвхөн тухайн хуулийн этгээдэд давуу байдал олгосон, түүнийг нотолсон мэт агуулга ажиглагдаж байна. *Тухайлбал,*

Бороогоулд ХХК-тай байгуулсан гэрээнд 2000 онд оруулсан өөрчлөлт нь:

- ТБГ-нд үйлдвэрийг ашиглалтад оруулах хугацааг заагаагүй орхигдуулсан, анхны гэрээнд “компанийн хөрөнгө оруулалт 15.0 сая ам.доллараас багагүй байна. Үүнээс 1999 онд 1.0, 2000 онд 14.0 сая ам.доллар гэсэн заалтыг эхний өөрчлөлтөөр “компанийн хөрөнгө оруулалт 25.0, үүнээс 1999 онд 1.0, 2000 онд 5.0, 2001 онд 15.0, 2002-2003 онд тус бүр 2.0 сая ам.доллар” гэж хуваарь, хэмжээнд өөрчлөлт оруулсан,
- Гэрээний үргэлжлэх хугацаа 10 жил байсан бол 2013 он хүртэл сунгаж 15 жил болгосон,
- Анхны гэрээний 2.2-т импортын болон дотоодод борлуулсан барааны НӨАТ-ыг 10 хувиар тооцохоор заасан боловч нэмэлт өөрчлөлтөд НӨАТ-аас чөлөөлөхөөр заасан,
- “Төслийг хэрэгжүүлэх хугацаанд олборлосон алтаа чөлөөтэй экспортолж болохыг Сангийн сайд үүгээр нотолж байна” гэж тухайн этгээдэд таатай боломж олгосон,
- Түүнчлэн “хэрэв энэхүү гэрээг байгуулснаас хойш компанид илүү таатай хууль тогтоомж батлагдвал тухайн таатай дэглэм эдлэх хүсэлтээ Сангийн сайдад бичгээр гаргаж болно,
- Шийдвэрлэж чадаагүй асуудлаар буюу “Тухайлбал ийнхүү шийдвэрлэж чадаагүй аливаа маргааныг Улс ба улсын иргэд, хуулийн этгээд хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг таслах тухай конвенцийн дагуу арбитраар шийдвэрлүүлэхдээ талууд үүгээр зөвшөөрч, арбитраар шүүхийн хурлыг Нью-Йорк хотноо хуралдуулах болно. Конвенцийн 25 (2) дугаар зүйлийн (b)-д нийцүүлж компанийг Их Британийн харъяалалтай гэж үзнэ ...” гэсэн байна.

1.11 Мөн уг гэрээний хувиуд адил хүчинтэй байх зохицуулалттай боловч Монгол болон Англи эх бичвэр хоорондоо зөрүүтэй байсан, Англи эх бичвэр нь аливаа маргааны шийдвэрлэгч байна гэсэн нь гэрээний мөрдөлт, хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд аливаа хүндрэлийг бий болгох эх үүсвэрийг тавьсан гэж үзэхээр байна. Мөн “Алт экспортлох асуудлаар Монголбанктай тусгайлан гэрээ байгуулж ажиллана” гэсэн заалтыг “Англи эх бичвэрт тусгагдаагүй” гэсэн үндэслэлээр хэрэгжүүлээгүй байна.

1.12 Түүнчлэн “Тогтвортой байдлын гэрээний загвар батлах тухай” Засгийн газрын 2005 оны 24 дүгээр тогтоолын 2 дахь хэсгийн “... салбарын үйл ажиллагааны онцлог байдлыг харгалзан нэмэлт зүйл, заалт, тодруулгыг хууль тогтоомжийн хүрээнд оруулж байх” заалт үндсэндээ хэрэгжээгүй байна.

1.13 Монгол Улсын Засгийн газартай “Тогтвортой байдлын гэрээ” байгуулсан хуулийн этгээд тухайн салбарт ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдээс зөрүүтэй татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх зохицуулалттай байгаа нь чөлөөт өрсөлдөөнийг хязгаарласан, тухайн компанид таатай нөхцөлийг бий болгосон сөрөг тал ажиглагдаж байна.

1.14 Мөн гэрээнд хөрөнгө оруулалтын арга хэлбэр тусгагдаагүйгээс хөрөнгө оруулалтын үр өгөөж тодорхой бус, түүний баталгаажуулалт хангалтгүй, чухам юуг хөрөнгө оруулалтаар тооцож, хэрхэн үнэлж дүгнэх, эдийн засгийн хөгжлийн шаардлагад нийцсэн бодитой хувь нэмэр, бүтээн байгуулалт болж үлдэх эсэхийг зохицуулалгүй орхисон байна.

1.15 Түүнчлэн ТБГ-нд ТЭХ, АМТХ болон ГХОТХ-ийн зөвхөн “Тогтвортой байдлын гэрээ” байгуулахтай холбоотой заалтыг үндэслэн гэрээний үндсэн зохицуулалтыг тодорхойлсон болохоос гэрээний хэрэгжилттэй холбоотой үүсч болох нөхцөл байдал, ялангуяа уул уурхайн салбарт байгаль орчинд нөлөөлөх байдал, мөн ажиллах хүч, нутгийн захиргаатай хэрхэн харьцах, гэрээг хэрхэн дүгнэж, үр дүнг мэдээлэх зэрэг асуудлууд тусгагдаагүй байна.

Хөрөнгө оруулалт хуваарийн дагуу хийгдсэн гэх боловч баталгаажилт болон хяналт хангалтгүй байна

1.16 ТБГ байгуулснаас хойш хөрөнгө оруулалтын хуваарь ёсоор эдгээр ААН нийт 518.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх амлалт авсан бөгөөд үүнд мөнгөн хэлбэрээр 21.0 сая ам.доллар, бусад хэлбэрээр 497.3 сая ам.доллар, үүнээс 2012 оны хөрөнгө оруулалтын жил дуусах хүртэл нийт 443.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээсэн байна.

1.17 ТБГ-нд хөрөнгө оруулалтыг бэлэн мөнгө, техник, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал, оюуны өмч болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад байдлаар хийхээр заасан бөгөөд Сангийн сайдын 1999 оны 49, 2002 оны 278 дугаар тушаалаар ТБГ байгуулсан хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын тайлангийн маягтыг баталжээ.

1.18 Маягтын дагуу хөрөнгө оруулалтын нэгдсэн тайланг бэлэн мөнгөөр, технологи ноу-хау шилжүүлэх, техник тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, материал, түүхий эд, хайгуулын ажил, барилга байгууламж, дэд бүтэц, бусад гэсэн төрлөөр холбогдох тайлбарын хамт гарган ирүүлэх учиртай ажээ.

1.19 ТБГ-тэй ААН-үүдийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2012 оны эцсийн байдлаар дараах байдалтай байна⁶. Үүнд:

№	ААН-ийн нэр	Хөрөнгө оруулалтын хэмжээ /сая ам.долл/		Тайлбар /анхны хөрөнгө оруулалтын эх үүсвэр/
		Гэрээний дагуу	гүйцэтгэл	
1	Цайрт минерал ХХК	21.0	65.1	Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр олгосон 200 сая юань
2	Бороогоулд ХХК	25.0	226.7	Хөрөнгө оруулагчийн эх үүсвэр
3	Востокнефтегаз ХХК	350.0	61.7	Хөрөнгө оруулагчийн эх үүсвэр
4	Эрин Интернэшнл ХХК	2.0	2.1	Хувь нийлүүлэгчдийн эх үүсвэр
5	Чин Хуа-МАК-Нарийн сухайт ХХК	5.3	48.5	Хувь нийлүүлэгчдийн эх үүсвэр

⁶ Сангийн яамны Төсвийн бодлогын газар, Орлогын хэлтсээс 2013 оны 3 дугаар сарын 25-нд ирүүлсэн мэдээлэл

6	Суруга Монгол ХХК	40.0	41.7	Зээлийн хөрөнгө
	Бүгд дүн	443.3	447.3	-

1.20 Сангийн яамнаас ирүүлсэн судалгаанаас харахад ТБГ-тэй ААН-үүдийн 2012 оныг дуустал хуваарийн дагуу хийгдвэл зохих хөрөнгө оруулалтын амлалт биелсэн буюу нийт гүйцэтгэл 100.9 хувь буюу 447.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

1.21 Гэвч Сангийн яаманд хөрөнгө оруулалтын үр дүн, үр нөлөөг үнэлж дүгнэсэн гэх судалгаа, баримт материал алга байна.

1.22 Технологи, ноу-хау шилжүүлэх талаар ТБГ байгуулсан ААН-үүд үндсэндээ тайлагнасан зүйлгүй байна.

1.23 Харин Суруга Монгол ХХК барилгын салбарт “Төмөр бетон бүтээцийн ган туйвангийн механик холбоо”, “Угсармал-Цутгамал төмөр бетон бүтээц” гэсэн 2 стандартыг Барилгын стандарчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэн батлуулжээ.

1.24 Востокнефтегаз ХХК-ийн хөрөнгө оруулалт 2008-2012 онуудад хийгдээгүй нь Алтандорнод ХХК-ийн татварын төлөлттэй холбогдуулан шүүхийн шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссонтой холбоотой байна.

Аудитын явцад Востокнефтегаз ХХК-ийн үйл ажиллагаатай танилцахад:

- Востокнефтегаз ХХК нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Рашаант дах “Нефть болон хий боловсруулах үйлдвэр”-ийн төслийн хүрээнд ажилчдын 29.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий орон сууц барьж байсан ч дээрх шалтгааны улмаас бүрэн баригдаагүй байна.
- Тухайн объектэд цахилгаан шугам сүлжээ, дамжуулах дэд станц, эрчим хүч, хашаа, усны дэд бүтэц шийдвэрлэгдсэн байна.
- Төслийн нэг хэсэг болох 24.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий “Нефть хангамжийн бааз” ашиглалтад орж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.

Шүүхийн шийдвэр 2012 онд цуцлагдсан хэдий ч дээрх төслийн хүрээнд хэрэгжсэн объектуудыг цаашид хэрхэн ашиглах, хөрөнгө оруулалтад тооцох эсэх нь тодорхойгүй байгааг анхаарч, гэрээн дэх хөрөнгө оруулалтын хуваарийг өөрчлөх шаардлага үүссэн байна.

1.25 ТБГ-тэй ААН-үүдийн хөрөнгө оруулалтын дийлэнхийг үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ үндсэн гол үйл ажиллагаанд чиглэгдсэн үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж, дэд бүтцээ бий болгох, техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, түүхий эд, материалд зориулсан хөрөнгө оруулалт эзэлж байна.

1.26 ТБГ-ний “Хөрөнгө оруулагчийн эрх үүрэг” гэсэн хэсэгт “хөрөнгө оруулалтын тайлангаа дараагийн жилийн эхний сард багтаан Сангийн яамны баталсан маягтын дагуу гаргаж, тухайн салбарын болон бусад холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан сайдад хүргүүлнэ”, харин “Сайдын эрх үүрэг” хэсэгт “хөрөнгө оруулалтаа хийж байгаа эсэхэд сайд тухайн салбарыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хяналт тавина” гэсэн заалт байна.

1.27 ТБГ-тэй эдгээр хуулийн этгээд батлагдсан маягтын дагуу хөрөнгө оруулалтын тайлангаа хүргүүлж байсан ч хөрөнгө оруулалтыг баталгаажуулж, хамтарсан хяналт хийгээгүй, мэргэжлийн байгууллагаас тайланд үнэлгээ дүгнэлт өгөөгүй байхад хөрөнгө оруулалтын тайланг хүлээн авч байгаа нь гэрээний 5.3 дахь заалтыг зөрчиж, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтын үр нөлөөг бууруулж байна.

Сангийн яам гэрээний хэрэгжилт, гэрээ дуусвар болж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, цаашид хэрхэх талаар тодорхой бодлогогүй байна

1.28 Уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй Цайрт Минерал, Бороогоулд ХХК-тай байгуулсан ТБГ-ний үйлчлэх хугацаа 2013 онд дуусвар болно. Цайрт Минерал ХХК-тай байгуулсан гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааны хувьд Сангийн яам, тухайн компанийн удирдлагын байр суурь зөрүүтэй байгаа боловч гэрээний хугацаа 2013 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр дуусвар болохоор байна⁷.

1.29 Иймд эхний ээлжинд гэрээний хэрэгжилтэд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, цаашид гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, аль эсвэл дуусвар болгох эсэх асуудлаар Сангийн яам санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх шаардлагатай юм.

1.30 Хэрэв гэрээг сунгах тохиолдолд 2006 онд шинэчлэн найруулсан АМТХ-ийн 5 дугаар зүйлийн “Ашигт малтмалын өмчлөл” хэсгийн 5.4-т “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно” гэж заасныг баримтлан төрийн оролцоог бий болгох асуудлыг гэрээнд тусгах нь зүйтэй.

1.31 Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй Цайрт минерал ХХК тогтоогдсон нөөцийн 45.7 хувь, Бороогоулд ХХК 91.9 хувь, Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК 28.1 хувийг тус тус ашиглаад байна.

1.32 Экспортолсон баялгийн үнэлгээг улс орон нутгийн төсөвт төлсөн татвар хураамжтай харьцуулахад улсын эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмэр бага байна. (Хүснэгт №4-г үзнэ үү.)

Хүснэгт №4

ААН-ийн нэр	Экспортолсон бүтээгдэхүүний хэмжээ	Гаалийн үнэлгээ /тбм.төг/	УОНТ-т төлсөн татвар хураамж /тбм.төгрөг/	Харьцуулалт /хувиар/
Цайрт минерал ХХК	894.3 мян.тн цайрын баяжмал	1 164.5	135.8	11.66
Бороогоулд ХХК	58.2 тонн алт	1 552.4	257.7	16.6
Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК	9700 мян.тн чулуун нүүрс	628.0	65.5	10.4

1.33 Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамжийг тонн тутамд 1000-1500 төгрөгөөр тооцохоос өөр татваргүй экспортолж байгаа нь эдийн засгийн ач холбогдол багатай байгааг харуулж буй тул холбогдох эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийн шинэчлэх шаардлагатай байна.

1.34 Бороогоулд ХХК-тай байгуулсан нэмэлт гэрээний 2.3-д “Компани үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортлоход экспортын татвар болон НӨАТ “0” хувь, харин алт олборлож Монгол банк эсвэл Монгол улсын нутаг дэвсгэр дээрх

⁷ Тогтвортой байдлын гэрээний талаарх Цайрт минерал ХХК-ийн 2013 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 2-43/2013, Сангийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 4-2/2384 дугаар албан бичиг

арилжааны аль нэг банкинд борлуулсан бол НӨАТ-ын 10 хувь төлөх”- өөр заажээ. Гэрээний тухайн заалт компанид ашигтай бөгөөд Монгол улсын татварт оруулах хувь хэмжээг бууруулсан, ач холбогдол багатай заалт болсон байна.

1.35 Востокнефтегаз ХХК-ийн шүүхийн маргаан болон Суруга Монгол ХХК-ийн барилгын зөвшөөрөл түр хугацаагаар цуцлагдаж байсныг эс тооцвол ТБГ-тэй хуулийн этгээд нь гэрээ байгуулснаас хойш 10 шахам жил үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж үйл ажиллагаа нь тогтворжсон гэж үзэж болно.

Одоо үйлчилж буй гэрээнд хөрөнгө оруулалтын арга хэлбэрийг оновчтой тодорхойлох замаар хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх боломж байна.

Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК 2012 оны эцсийн байдлаар 24.7 сая тонн нүүрсний нөөцийн үлдэгдэлтэй бөгөөд олборлосон бүтээгдэхүүндээ боловсруулалт хийдэггүй байна. Харин уул уурхайн экспортын голлох бүтээгдэхүүн болох чулуун нүүрсэнд дахин боловсруулалт хийснээр эдийн засгийн үр ашиг нэмэгдэх боломж байна.

Суруга Монгол ХХК барилгын салбарт орон сууц, инженерийн дэд бүтцийг барьж байгуулсан хэдий ч хэрэглэгчид болон худалдан авагчдын төлбөрийн чадвартай нийцүүлж, Засгийн газраас хэрэгжүүлж буй иргэдийг орон сууцжуулах төсөл, хөтөлбөртэй уялдуулан хөрөнгө оруулалтыг чиглүүлэх нь зүйтэй байна.

1.36 Цаашид Сангийн яам, холбогдох бусад байгууллагатай хамтран ашигт малтмалын болон гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн “тогтвортой байдлын гэрээ”, “хөрөнгө оруулалтын гэрээ”-ний талаарх заалтыг хянаж үзэх шаардлагатай байна.⁸

1.37 Мөн хугацаа нь дуусах болоогүй “Тогтвортой байдлын гэрээ”-нд доорх асуудлыг нэмж тусгах нь зүйтэй байна.

Тухайлбал:

- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20.1, 20.2, 20.3-т заасан хугацааг дахин авч үзэх, мэргэжлийн болон хөндлөнгийн байгууллагын санал, дүгнэлтийг хүлээн авдаг байх,
- Хөрөнгө оруулалтын мөнгөн ба бусад хэлбэр, хэмжээ, баталгаажуулалт, тооцох аргачлал, түүнийг хэрхэн харилцан хүлээн зөвшөөрч байхыг тодорхой болгох,
- Хөрөнгө оруулалтын үнэлгээ, үр дүн, эдийн засгийн ач холбогдлыг тодорхой болгох,
- Хөрөнгө оруулалтыг дагасан эдийн засгийн өсөлт нь орон нутгийн хөгжилтэй хэрхэн уялдах, үр өгөөжийг тооцдог болгох, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тусгах, хэлэлцэж байх нөхцөлийг бүрдүүлэх,
- Гэрээний хэрэгжилт, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлдэг болгох.

1.38 Түүнчлэн дээрх компаниудтай байгуулсан ТБГ-нд экспортолсон бүтээгдэхүүний орлогын тодорхой хэсгийг Монгол улсын банкинд байршуулах асуудлыг тусгах нь зүйтэй байна.

Бүс, орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалтын зарим ажлын талаар

1.39 Цайрт минерал ХХК 2.7, Бороогоулд ХХК 17.2, Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК 26.9 тэрбум төгрөгийн дэмжлэгийг орон нутагт үзүүлжээ.

⁸ Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйл /1997 он/, Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйл /2006 он/, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйл.

- Бороогоулд ХХК “Орон нутаг хөгжүүлэх сан” байгуулж түүгээрээ дамжуулан сум, орон нутагт тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд 2004–2012 оны хооронд нийт 5.8 сая ам.доллар буюу 7.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний дийлэнх нь дэд бүтцийг сайжруулах, өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэгджээ.
- Улаанбаатар хотын 1 дүгээр амаржих газрын өргөтгөлд Бороогоулд ХХК-ийн 1.5 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэй эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг ЭМЯ хариуцаж ажилласан ч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21.3-д заасныг болон сонгон шалгаруулахад баримтлах босго үнэ зэргийг баримтлаагүй, зөвхөн үнийн санал авснаар гэрээ байгуулан тоног төхөөрөмж нийлүүлсэн ба үнийн саналд тоног төхөөрөмжийн зарим иж бүрдлийг тусгаагүйгээс ашиглагдах боломжгүйд хүргэж, нэмэлт хөрөнгө шаардагдсан байна.
- ЭМЯ, Нью Телеком ХХК-ийн хооронд байгуулсан ЭМЯ-ТТ-2012-001 дугаартай “Тоног төхөөрөмж худалдан авах гэрээ”-ний 3.3-т худалдан авалттай холбогдон гарах татвар, хураамж багтсан боловч тус компани НӨАТ төлөөгүй байсан тул аудитын явцад төлүүлэв.



1.40 Цайрт минерал ХХК Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод төвлөрсөн дэд бүтэц бүхий 72 айлын орон сууц, аймгийн төвд автозам барих, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, төв талбайг шинэчлэх, эмнэлэг, сургууль, соёлын төвийг засаж тохижуулахад тодорхой хөрөнгө зарцуулсны дотор 2.7 тэрбум төгрөгийн тусламж үзүүлжээ.

1.41 Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК дэд бүтцийг хөгжүүлэх буюу Нарийн сухайтын уурхайгаас Шивээхүрэнгийн боомт хүртэл 56 км хатуу хучилттай зам, мөн уурхайгаас Гурван тэс сум хүртэл 10/0.4 квт-ын өндөр хүчдэлийн 25.9 км цахилгаан дамжуулах шугам, дэд станц, хүүхэд залуучуудын урлаг, спортын төвийн барилгыг ашиглалтад оруулсан байна.

1.42 Гэвч уурхайгаас Шивээхүрэнгийн боомт хүртэл тавьсан хатуу хучилттай зам орон нутагт дэмжлэг үзүүлэх гэхээсээ зөвхөн өөрийн компанийн тээвэрлэлтийг дэмжих зорилгоор тавигдсан гэж үзэж болохоор байна. Аудитын баг, Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК-ийн Улаанбаатар дахь суурин төлөөлөгчийн газрын удирдлагатай хийсэн ярилцлагаас үзэхэд дээрх замыг экспортын тээвэрлэлтэд ашиглахгүй байгаа нь түүний даац бага байгаатай холбоотой юм. Өөрөөр хэлбэл энэ зам нүүрс экспортлох шаардлага хангаагүй зам гэж үзэж болохоор байна.



Бүлэг 2. Гэрээтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байна

Засгийн газраас 1997, 2002 онд баталсан “Тогтвортой байдлын гэрээний загвар”-т гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон ямар нэгэн маргаантай асуудал үүсвэл талууд аль болох хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэх, нэгдсэн шийдэлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжоор шийдвэрлүүлэх, 2005 онд баталсан загварт талууд маргааныг эв зүйгээр харилцан тохиролцож шийдвэрлэнэ гэжээ.

Мөн гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулах ба гэрээний хугацаа дууссан болон хөрөнгө оруулагч гэрээг цуцлах тухай хүсэлт гаргасны дагуу хоёр тал бичгээр харилцан тохиролцсон, ААН дампуурсан, хууль тогтоомж зөрчсөний учир эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааг нь бүрэн зогсоосон, гэрээний үүргийг бусдад шилжүүлсэн тохиолдлуудад гэрээ дуусвар болохоор зохицуулагдсан байна.

Монгол Улсын хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна

2.1 МХЕГ-аас Бороогоулд ХХК-д 2009 оны 10 дугаар сард хийсэн шалгалтаар бусдаас шилжүүлэн авсан тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон ч тухайн ордод тооцогдсон нөөцийн хөдөлгөөний хөтлөлт, түүний бүртгэл хийгдээгүй байсныг тогтоожээ⁹.

2.2 Түүнчлэн Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК-д 2012 оны 4 дүгээр сард хийсэн хяналт шалгалтаар “Тогтвортой байдлын гэрээ”-ний 3.1, 3.4 болон Байгаль орчин, геологи уул уурхай, газрын харилцаа, геодези зураг зүй, дэд бүтэц, эрүүл ахуй, халдвар судлал, хүнсний аюулгүй байдал, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр Монгол Улсын хууль тогтоомж, журам, дүрэм, холбогдох стандартын 70 гаруй зүйл заалтыг зөрчсөн зөрчил илэрч байжээ¹⁰.

2.3 АМТХ-ийн 43.1-д “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх ...”-ээр заасан бөгөөд Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК-д ажиллагсдын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэлийн тайлангаар зарим монгол ажилчдыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж ирсэн байна.¹¹

2.4 Тухайлбал, зөвхөн 2011 оны 2 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдлаас үзэхэд Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулсан бүгд 58 ажилтан байжээ.

Монгол улсын иргэдийг ажиллуулахдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулсан нь нийт монгол ажилчдын тоог өсгөх, уг тоонд нийцүүлэн АМТХ-ийн 43 дугаар зүйлд зааснаар гадаад ажилчдын тоог нэмэх, цаашилбал, хуулиар тогтоосон ажлын байрны төлбөрөөс зайлсхийсэн үйлдэл байж болох юм.

⁹ ҮАГ-т МХЕГ-аас ирүүлсэн 2013 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 3/1378 тоот харцу бичиг

¹⁰ Мөн МХЕГ-аас ирүүлсэн тайлбар, тодруулга

¹¹ Засгийн газрын “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг батлах тухай 2007 оны 350, 2011 оны 241 дүгээр тогтоол (108000 төгрөг, 140400 төгрөг)

2.5 Гэрээтэй ААН-үүдээс Суруга Монгол ХХК-ийн 2008-2010 оны үйл ажиллагаанд гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийгдсэн, бусад ААН энэ шалгалтад хамрагдаагүй байна.

2.6 Гэрээ байгуулагдах үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжийг гэрээний хугацаанд мөрдөхөөр заасан боловч зарим төрлийн төлбөр хураамжийг тусгаагүй, ерөнхийлөн оруулснаас холбогдох байгууллага ААН-ийн хооронд орон нутагт үйлчлэх хураамж, төлбөрийн ногдуулалт, төлөлттэй холбоотой үл ойлголцол үүсч байна.

“Төмөртийн Овоо”-ны ордын нөөцөд тогтоогдсон дагалдагч металлыг үнэлээгүй байна

2.7 “Төмөртийн Овоо”-ны цайрын ордын УБҮ ашиглалтад орж, олборлолт эхэлсэнтэй зэрэгцүүлэн, ордын хүдрийн нөөцийг өсгөх хайгуулын ажил хийгдэж байгаа боловч нөөц шинэчлэн бүртгэгдээгүй байна.

2.8 “Metalls Mongolia-2011” чуулга уулзалтын илтгэлд “Манай орны ихэнх нөөцийг бүрдүүлж буй Төмөртийн овоо, Улаан, Цав зэрэг ордууд нь зүүн бүсэд хамаарч байгааг харгалзан үзэж тус бүсэд жилд 50000 тонн цэвэр цайр үйлдвэрлэх металлургийн үйлдвэрийг байгуулах боломжтойн зэрэгцээ тус үйлдвэрийг байгуулах урьдчилсан ТЭЗҮ-д дайвар бүтээгдэхүүнд жилд 79 тонн кадмий, 27000 тонн хүхрийн баяжмал үйлдвэрлэхээр тооцсон” гэж дурьджээ¹³.

2.9 Дурдагдсан металлууд нь дэлхийн зах зээлд үнэ болон хэрэглээгээр чухалд тооцогддог бөгөөд индий нь алтнаас хэд дахин илүү үнэтэй ба дэлхийн индийн нөөцийг 20 жил орчим байна гэж судлаачид тооцсон байдаг¹⁴.

2.10 Лабораторийн шинжилгээний харьцуулалтад кадмийн агуулга 0.1 хувьтай байгаа нь металлын үнийг баяжмалын үнэд шингээн тооцох шаардлагатай гэж

Төмөртийн овооны цайрын ордын тухай:

Ордын нөөцийг тогтоосон комиссын хуралдааны тэмдэглэлд ордын хүдрийн нөөц /B+C1+C2/ 7193.2 мянган тонн, металл цайрын нөөц 1101.04 мянган тонн, дагалдах ашигт малтмал болох кадмийн 0.0228 хувийн агуулгатай 2027 тонн металлын нөөц, индийн 0.002 хувийн агуулгатай 218 тонн металлын нөөц, 23.4 хувийн агуулгатай төмрийн 1324.0 мян.тн металлын нөөцтэйг тооцжээ¹².

Дээрх тэмдэглэлд:

- Цайрын хүдрийг ашиглах явцад олборлох шаардлагатай кадмийн нөөцийг ил аргаар уурхайлалт хийгдэхээр дахин тооцоологдсон цайрын хүдрийн нөөцтэй уялдуулан, тайланд тодорхойлсон хэмжээг үндэс болгон балансад хүлээж авах,
- Ордын төмрийн хүдрийг УААА-д ашиглах, тухайлбал магнетитын баяжмалыг зүй зохистой хэрэглэх асуудлыг шийдвэрлэх,
- ЗХУ-д хийгдэх, тус ордын төмрийн хүдрийн технологийн судалгааг шуурхайлан гаргуулж, цайр болон магнетитын баяжмалын гарц ба чанарын талаар үндэслэл сайтай материалыг бэлтгэж үйлдвэрийн зураг төсөлд тусгуулах,
- Тус районд цайрын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн геологийн судалгааг эрчимжүүлж, районы эрдэс түүхий эдийн цогцолбор үнэлгээг хийлгэх зэрэг асуудал тэмдэглэгдэн үлджээ.

¹² Ордын геологи, хайгуулын ажлыг Монгол-Германы хамтарсан хайгуулын анги 1974-1979 онд хийж, нөөцийг 1980 онд БНМАУ, БНАГУ, ЗСБНХУ-ын /хуучин нэрээр/ ашигт малтмалын нөөцийн комиссын хамтарсан хуралдаанаар баталсан тэмдэглэл,

¹³ “Рефайнерс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Бямбажавын тавьсан илтгэлээс, эх сурвалж, <http://www.mininginvestment.mn/>

¹⁴ Эх сурвалж: <https://en.wikipedia.org/>

тодорхойлсон¹⁵ нь дээр дурьдсаныг давхар нотолж байна. *Лүүнийг хүснэгт №5-аас үзнэ үү/*

Хүснэгт №5

Ашигт малтмалын төрөл	Гаалийн төв лаборатори /2012.07.26/	Геологийн төв лаборатори /2012.07.24/	Цайрт минерал ХХК-ийн лаборатори /2012.01 сар/	Хүлээн авагч талын лаборатори /2012.01 сар/	"SGS Mongolia" ХХК-ийн лаборатори, "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн шинжилгээний төв лаборатори /2011-01 сар/		
					Хүдэр	Баяжмал	Хаягдал
Баяжмал							
Цайр, Zn	50.46 %	50.42 %	51.7 %	51.8 %	14.45 %	51.6 %	2.42 %
Төмөр, Fe	-	-	-	-	30.20 %	7.92 %	42.1 %
Кадми, Cd	-	-	0.11 %	0.11 %	0.03 %	0.1 %	<0.01 %
Индий, In	-	-	-	-	-	-	-
Кобальт, Co	-	-	0.05 %	0.05 %	137 г/тн	411 г/тн	53 г/тн

2.11 Гэтэл индийг тодорхойлох аргачлалгүйгээс тус элементийн агуулгыг тодорхойлж чадахгүй байна.

2.12 Графикт үзүүлснээр 2008-2012 онд 1 тонн металл кадмийн дэлхийн зах зээлийн үнэ дунджаар 3000 ам.долларт хэлбэлзэж байжээ. */Доорхи зурагт тайлбарыг үзнэ үү/*

*Кадмийн дэлхийн зах зээлийн үнийн үзүүлэлт /2008-2013 он/, гол хэрэглээ ба ашиглалт**



*Эх сурвалж: <http://www.metalprices.com/>

Дэлхийн хамгийн том кадми үйлдвэрлэгч орон нь БНХАУ, хэрэглэгч нь Хятад болон Япон улс юм.

Гол хэрэглээ нь дахин цэнэглэдэг никель-кадмийн батерей хийх, сайжруулсан ган болон металл хайлшийг бүрэх, цөмийн технологид түүнийг ашигладаг.

*Эх сурвалж: <https://en.wikipedia.org/>

2.13 Металл индийн дэлхийн зах зээлийн үнэ 2008-2012 онд дунджаар 1 тонн 600.0 мянган ам.долларт хэлбэлзэж байжээ. */Доорхи зурагт тайлбарыг үзнэ үү/*

*Индийн дэлхийн зах зээлийн үнийн үзүүлэлт /2008-2013 он/, гол хэрэглээ ба ашиглалт**

Индийн томоохон үйлдвэрлэгчдэд Хятад, Канад, Япон, Өмнөд Солонгос зэрэг орнууд ордог бөгөөд шингэн кристалл болон өөрөө мэдрэгч дэлгэц хийх, компьютер, техник технологи эрчимтэй хөгжиж буй энэ эрин зуунд чухал түүхий эд болгон ашиглаж байна. 2006-2009 онд 1 тонн инди 382000-912000 ам.долларт хүрч байжээ*.

*Эх сурвалж: <https://en.wikipedia.org/>



*Эх сурвалж: <http://www.metalprices.com/>

¹⁵ "Төмөртийн овооны цайрын ордын хүдрийн баяжуулалт, үйлдвэрийн технологийн аудит"-ын тайлан /Эрдэнэт хот, 2011 он/

2.14 Хүснэгт №6-д тус компанийн УБҮ ашиглалтад орж, үйлдвэрлэл эхэлснээс хойш нийт 599.9 тонн кадми агуулсан, 1.1 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий 894.3 мян.тн цайрын баяжмал экспортод гаргажээ. /Үүнийг хүснэгт №6-гаас үзнэ үү/

Хүснэгт №6

Он	Уулын ажлын тайлант мэдээ					Гаалийн ерөнхий газрын мэдээ	
	Балансын			Балансын бус		Экспорт мян.тн	Суурь үнэлгээ, /дэлхийн зах зээлийн үнэ тбм.төг/
	Олборлосон металл, мян.тн	Олборлосон кадми, тн	Олборлосон хүдэр, мян.тн	Олборлосон металл, мян.тн	Олборлосон хүдэр, мян.тн		
2005	28.21	44.0	186.00	15.4	68.56	23.1	12.5
2006	69.53	87.0	272.03	4.9	20.67	103.8	106.3
2007	62.10	81.0	302.47	38.21	73.65	127.1	198.1
2008	95.36	95.34	506.29	-	-	135.4	177.7
2009	76.36	-	468.24	-	-	150.6	176.1
2010	54.44	107.8	466.81	-	-	113.9	171.1
2011	58.44	85.61	380.82	-	-	101.9	148.1
2012	58.8	99.19	441.48	-	-	138.5	174.6
Бүгд	503.24	599.94	3024.14	58.51	162.88	894.3	1164.5

2.15 Хүснэгтээс харахад 2005-2012 онд нийт 599.94 тонн кадми олборлосныг дэлхийн зах зээлийн дундаж үнэ ханшаар тооцоход 1.8 сая ам.доллартай тэнцэхүйц энгийн тооцоо гарч байна. Харин индийн нөөц кадмийгаас 10 дахин бага буюу 59.0 тонн гэж үзвэл 35.4 сая ам.доллартай тэнцэхүйц байгаа бөгөөд энэ нь ихээхэн хэмжээний нөөц баялгийг үнэлж тооцохгүй байгаагийн жишээ юм.

Ордын нөөцийн үлдэгдлийг 2012 оны эцсийн байдлаар авч үзвэл хүдэр 4,632.9 мянган тонн, цайр 508.97 мянган тонн, кадми 960.42 тонн байна.

2.16 Төмрийн агуулга хүдэрт 30.2%, баяжмалд 7.92%, хаягдалд 42.1% байгаа нь тус үйлдвэрийн технологийн хаягдал төмрийн баяжуулах үйлдвэрийн түүхий эд болохыг харуулж байна.

Зураг №1. Төмрийн исэлдсэн хүдрийн овоолго

2.17 Гэвч өнөөгийн байдлаар төмрийн исэлдсэн хүдрийн ил овоолго болон хаягдлын сангийн үүсмэл ордыг ашиглах төсөл, төлөвлөгөө боловсруулагдаагүй байна. /Зураг №1/



2.18 Гаалийн төв лабораторийн хүсэлтийн дагуу Геологийн төв лабораторт баяжмал дахь дагалдах элементийг тодорхойлж байжээ.

2.19 Засгийн газрын 2007 оны 88, 2010 оны 39, 2013 оны 131 дүгээр тогтоолд уул уурхайн бүтээгдэхүүний тухайн сард баримтлах жишиг үнийг тодорхойлсон боловч дээрх металлууд тогтоолд нэр заагдаагүй байна.

Иймд Сангийн яам, холбогдох байгууллагууд дагалдах элементэд баримтлах жишиг үнийг тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Бороогийн ордын нийт баялгийг бүрэн ашиглах төлөвлөгөөгүй байна

2.20 Бороогоулд ХХК Бороогийн үндсэн ордыг ашиглах явцад нөөцийг нэмэгдүүлэх, баталгаажуулах зорилгоор 2 удаа нөөцийг шинэчлэн бүртгүүлжээ.

2.21 Ил уурхайн үндсэн ордын олборлолт 2010 оны 11 дүгээр сард дууссан бөгөөд одоогийн байдлаар бага агуулгатай буюу балансын бус хүдрээс алтыг нуруулдан уусгах аргаар ялгах үйлдвэрлэл явагдаж байна.

Бороогийн алтны ордын нөөцийн тухай:

- Ордын нөөцийг тогтоосон комиссын тогтоолд /В+С1/ 43 тонн алтны нөөц баталж байжээ.¹⁶
- АМГТХЭГ-ийн даргын 2008 оны 426 дугаар тушаалаар бороогийн ордын нийт нөөцийг 38390 кг, үүнээс 28375 кг үйлдвэрийн нөөц, нуруулдан уусгалтын 10015 кг нөөцийг шинэчлэн бүртгүүлжээ.

2.22 2012 эцсийн байдлаар нуруулдан уусгах төслийн нөөц нь 9.7 сая тонн хүдэр бүхий 5174 кг алтны нөөцтэй ба уг нөөц нь ЭБМЗ-өөр хэлэлцэгдээгүй бөгөөд үйлдвэрлэл 2014 оныг дуустал үргэлжлэхээр байна.

2.23 Тус компани ТБГ байгуулан, УБҮ ашиглалтад орж, үйлдвэрлэл эхэлснээс хойш 2003-2012 онд нийт 29.3 сая тонн хүдэр боловсруулж, 1.55 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий 58.2 тонн алт экспортолсон байна. (Хүснэгт №7-г үзнэ үү.)

Хүснэгт №7

Он	Үйлдвэрээр боловсруулсан нөөц, кг				Нуруулдан уусгалтаар боловсруулсан нөөц, кг				ГЕГ-ийн мэдээ	
	хүдэр мян.тн	агуулга, г/тн	алт, кг	мөнгө, кг	хүдэр мян.тн	агуулга, г/тн	алт, кг	мөнгө, кг	экспорт, кг	үнэлгээ, /тбм.төг/
2003	105	3.28	344						-	-
2004	1849	4.48	8276						8428.8	117.117
2005	2494	3.68	9180	1057					9549.2	146.168
2006	2387	3.94	9405	1245					10096.1	200.986
2007	2548	3.61	9221	1196					8818.7	208.023
2008	2496	2.69	6708	1115	2425	0.66	783	108	7042.6	203.175
2009	2077	2.56	5327	752	3941	0.37	800	113	5375.2	211.718
2010	2466	1.86	4596	642	563	0.41	154	21	4128.9	191.550
2011	2340	1.10	2595	387	354	0.29	45	6	2106.8	113.674
2012	2382	1.31	3130	541	903	0.70	233	37	2682.3	160.015
Бүгд	21144		58782	6935	8186		2015	285	58228.6	1552.426

2.24 Бороогийн алтны үндсэн ордыг ашиглах ТЭЗҮ-ийг 2001 онд хэлэлцэн баталсан бөгөөд ордыг ил аргаар тээвэрлэлттэй системээр ашиглан жилд дунджаар 1.3 сая тонн хүдэр олборлон баяжуулах үйлдвэрт СІL технологиор боловсруулан 10 жилийн хугацаанд жилд дунджаар 3.9-4.9 тонн алт гаргахаар тооцжээ.

¹⁶ Бороогийн алтны ордын геологи хайгуулын ажлыг Монгол-Германы хамтарсан хайгуулын анги 1982-1989 онд хийж, нөөцийг 1992 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн /хуучин нэрээр/ “БНМАУ, Улсын ашигт малтмалын нөөцийн комисс”-ын 08 тоот тогтоолоор баталжээ.

2.25 Гэвч дээрх хүснэгтээс харахад жилд бүрэн хүчин чадлаараа дунджаар /2004-2010 он/ 2.3 сая тонн хүдэр боловсруулж төслийн хүчин чадлын төлөвлөлтөөсөө 1 сая тонн буюу 1.8 дахин илүү хүдрийн боловсруулалт хийжээ.

2.26 Үндсэн ордоос 2, 3, 5 ба 6 гэсэн 4 ил уурхайгаас олборлолт хийгдсэн бөгөөд ашиглалтын явцад 2 ба 3-р уурхайнууд нийлж нэг том уурхай болжээ. /Зураг №2/

Зураг №2 “Бороогийн алтны үндсэн орд”-ын 2 ба 3-р ил уурхайн зураг



2.27 “Бороогийн алт” төслийн анхны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу “... уул уурхайн ажилд байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай хамгийн дэвшилтэт арга, техник, туршлагыг хэрэглэснээр байгалийн унаган төрх, газрын элэгдэл, өөрчлөлтийг аль болох багасгах, ашиглалт дууссаны дараа бүрэн нөхөн сэргээхийг удирдамж болгох, төслийг хэрэгжүүлэх үед болон хэрэгжсэний дараа уурхайн ажлыг сайтар төлөвлөх, ухсан орон зайг хатуу хаягдал, чулуулгаар дүүргэх, тэгшлэх” зэрэг ажлууд хийгдсэн байх ёстой¹⁷.

2.28 Гэвч үндсэн ордын ашиглалтаас хойш буюу 2010 оны 11 дүгээр сараас өнөөдрийг хүртэл ил уурхайд нөхөн сэргээлт хийгдээгүй байна.

2.29 Ил уурхайн хана болон ул зэрэг тодорхой хэсгүүдэд 1.11 гр/тоннын дундаж агуулгатай, 13.1 тонн баялгийн тооцоо гарсан ч цаашид хэрхэн ашиглах талаар тодорхой шийдвэр гараагүй байна.

2.30 Үндсэн ордын 90.0 гаруй хувийг ашигласан, ТБГ-ний хугацаа 2013 оны 7 сард дуусвар болж байхад үлдэгдэл баялаг ашиг багатай гэсэн тооцоо гарсан бөгөөд цаашид ордыг бүрэн ашиглах эсэх, байгаль орчны нөхөн сэргээлтийг хэдийд, хэрхэн хийж дуусгах нь тодорхойгүй байна.

Цаашид тухайн ордыг иж бүрнээр ашиглахгүй тохиолдолд АМТХ-ийн 35 дугаар зүйлийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг”-ийн 35.5-д “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно” гэсэн заалт зөрчигдөхөөр байна. Иймд дараагийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүрвэл ордыг иж бүрэн ашиглах, ил уурхайн нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэсэн байх шаардлага тавигдана.


¹⁷ Эх сурвалж: ЖЭМР ХХК-ийн 2000 онд хийсэн БОНБНУ-ий тайлан

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Тогтвортой байдлын гэрээг тухайн үеийн хууль, эрх зүйн орчинд нийцүүлэн байгуулсан ч хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөж арга хэлбэр, байгаль орчинд нөлөөлөх байдал, ажиллах хүч, орон нутгийн захиргаатай харьцах, гэрээг дүгнэх, үр дүнг тооцож мэдээлэх зэрэг асуудал орхигдож, гэрээнд оруулсан зарим нэмэлт өөрчлөлт зөвхөн тухайн компанид таатай нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.
- Хөрөнгө оруулалтын тайланг мэргэжлийн байгууллагаар хянуулж баталгаажуулаагүй, үр нөлөөг тооцохгүй байгаа нь гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйг харуулж байна.
- Үргэлжлэн хэрэгжиж байгаа тогтвортой байдлын гэрээнд орон нутгийн оролцоо болон хөрөнгө оруулалтын талаар тодорхой тусгаагүйгээс улс орны түвшинд бодитой хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.
- Тогтвортой байдлын гэрээнд татвар хураамжийн төрөл, хөнгөлөлт, чөлөөлөлт, зарим хууль тогтоомжийн өөрчлөлтийг даган мөрдөх талаар тодорхой тусгаагүйгээс талуудын хооронд үл ойлголцол бий болж байна. Ялангуяа Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК байгаль орчин, уул уурхай, дэд бүтэц, хөдөлмөр, эрүүл ахуй, аюулгүй байдлын чиглэлээр хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүй байна.
- Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй Цайрт минерал ХХК тогтоогдсон нөөцийн 45.7 хувь, Бороогоулд ХХК 91.9 хувь, Чин Хуа-Мак-Нарийн сухайт ХХК 28.1 хувийг тус тус ашиглаад байна.
- Бороогоулд ХХК-ийн гэрээний хугацаа 2013 онд дуусахаар байхад үлдэгдэл баялгийг цаашид ашиглах талаар тодорхой шийдвэргүй, байгаль орчны төгсгөлийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө батлагдаагүй байна.
- Төмөртийн овооны цайрын ордын нөөц шинэчлэн бүртгэгдээгүй, өмнө бүртгэгдсэн цайрын баяжмал дахь эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдагч баялгийг үнэлээгүй, төмрийн хүдрийг ашиглах төлөвлөгөөгүйгээс ихээхэн хэмжээний нөөц боломжийг алдаж байна.

1. Сангийн яамнаас ирүүлсэн санал:



Тайлбар 1.1-ийг үзнэ үү.

Тайлбар 1.2-ыг үзнэ үү.

Тайлбар 1.3-ыг үзнэ үү.

заасны дагуу татварын хувь хэмжээг нэмэгдүүлэлгүйгээр, бизнест эзлтэй, хөрөнгө оруулалтыг дэмжихүйц татварын бодлогыг баримтлахаар зорьж байна. Түүнчлэн Засгийн газраас Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, түүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тогтворжуулахаар заасан нь уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг татах нэг арга зам юм. Иймд уул уурхайн бүтээгдэхүүний экспортын татварыг бий болгох тул зөвлөмжийг шууд хүлээн авах боломжгүй байна.

Зөвлөмж 4: Ашигт малтмалын болон гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн хөрөнгө оруулалт, тогтвортой байдлын гэрээтэй холбоотой хэсэгт өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

Тайлбар 4: Тогтвортой байдлын гэрээг 1997 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Ашигт малтмалын тухай хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар тус тус зохицуулж ирсэн. Түүнчлэн Монгол Улс хөрөнгө оруулалтыг дэмжих, түүний эрх зүйн орчны баталгааг хангах чиглэлээр хоёр талт болон олон талт гэрээ, конвенцод нэгдэн орсон. Тухайлбал: Улс болон бусад улсын иргэдийн хооронд хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай 1965 оны Вашингтоны конвенц, Монгол Улсаас бусад улстай байгуулсан Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай 2 талт гэрээнүүдтэй бөгөөд эдгээр нь Монгол Улсын хууль, тогтоомжийн нэг хэсэг юм. Иймд холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж болох ч энэ нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод зааснаас өөрөөр заах боломжгүй юм. Нөгөө талаас Засгийн газраас санаачлан УИХ-д өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслөөр холбогдох хуулиудад өөрчлөлт оруулахаар боловсруулагдан хэлэлцэгдэж байна. Иймд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хэлэлцүүлгээс шууд хамаарахаар байна.

Түүнчлэн аудитын тайлантай холбогдуулан нэмж дараах тайлбарыг гаргаж байна. Үүнд:

1. Тогтвортой байдлын гэрээнүүдэд орсон өөрчлөлтүүд нь холбогдох олон улсын гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна. Энэ нь:

- 1.1. Хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн тул хуулийн дагуу гэрээний хугацааг сунгасан;
- 1.2. Гэрээний зарим ойлгомжгүй зүйл заалтыг тодруулах зорилгоор хийсэн;
- 1.3. Түүнчлэн татварын 1 дэх шатны шинэчлэлийн хүрээнд татварын хувь хэмжээ буурсантай холбогдуулан өмнө үйлчилж байсан хуулийг бус шинэ тааламжтай нөхцөл олгож байгаа хуулийг сонгон хэрэглэх олон улсын нийтлэг зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор тус тус өөрчлөлтүүд орж байсан болно.

2. Гэрээний хүрээнд оруулж буй хөрөнгө оруулалт нь Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар тодорхойлогдсон хөрөнгө оруулалтад хамаарах тул хөрөнгө оруулалт, түүний хэлбэрийг хуульд зааснаас өөрөөр тогтоох эрх Сангийн сайдад олгогдоогүй бөгөөд үүнийг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг зөрчихөөр байна.

Тайлбар 1.4-ийг
үзнэ үү.

Тайлбар 1.5-ыг
үзнэ үү.

3. Тогтвортой байдлын гэрээ нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны тогтвортой орчинг хангах зорилгоор байгуулагддаг бөгөөд Сангийн сайд нь гэрээлэгчийн хувьд хөрөнгө оруулагчийн нийгмийн хариуцлагын талаар шаардлага тавих эрхтэй. Гэвч тус шаардлага нь эрх хэмжээний хувьд салбарын яамд, төрийн захиргааны байгууллагуудын гаргасан дүгнэлтэд үндэслэх ёстой юм.


Хүндэтгэсэн.

САЙД



Ч.УЛААН

2. Уул уурхайн яамнаас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙН ЯАМ

15100 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-08, Факс: (976-11) 31-81-09

2013.10.01 № 3/2269
танай 2013.09.16-ны № 979 -Т


МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ Б.БАТБАЯР ТАНАА

Танайхаас ирүүлсэн "Тогтвортой байдлын гэрээний хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Уул уурхайн сайдад өгсөн аудитын зөвлөмж нь бодлогын хүрээнд доорх байдлаар хэрэгжих байна. Үүнд:

1. Бороогийн алтны ордод 2013 оны 4 дүгээр сард нуруулдан уусгах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа. Цаашид баяжуулах, боловсруулах үйлдвэрийн улсын үзлэг хийхэд тогтвортой байдлын гэрээ бүхий эдгээр аж ахуй нэгжүүд хамрагдах болно.
2. Бороогийн ордыг цаашид иж бүрэн ашиглах чиглэлээр үлдэгдэл нөөцийг дахин тооцож, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг хийж байна. Ил уурхайн нөхөн сэргээлтийн чиглэлээр БОНХЯ-аар уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг батлуулсан ба жил бүр дунджаар 40 га талбайд нөхөн сэргээлт хийж байна. 2012 оны байдлаар 359 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.
3. Төмөртийн овооны цайрын ордын үйлдвэрлэлийн нөөцийг шинэчлэн тогтоох, дагалдах ашигт малтмалыг тооцох үүднээс ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс шинжээч томилон ажиллаж байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Р.ЖИГЖИД

Тайлбар 2.1-ийг үзнэ үү.

Сангийн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар 1.1

Тодорхой санал ирүүлээгүй тул зөвлөмжид өөрчлөлт хийгээгүй болно.

Тайлбар 1.2

Тодорхой санал ирүүлээгүй тул зөвлөмжид өөрчлөлт хийгээгүй болно.

Тайлбар 1.3

Ирүүлсэн санал нь зөвлөмжийн агуулгаас өөр тайлбартай байна.

Зөвлөмжид өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Тайлбар 1.4

Засгийн газраас Улсын Их хуралд шинээр болон дагалдах хуулиудын төслийг өргөн барьсантай холбогдуулан зөвлөмжийн уг заалтыг хасав.

Тайлбар 1.6

Тус яамны “Тогтвортой байдлын гэрээ”-г хариуцсан ажилтнууд тайлангийн төсөлтэй сайтар танилцаж, агуулгыг бүрэн ойлгоогүй байна. Тухайлбал, тайлангийн төсөлд тодорхой аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах болон нэмэлт өөрчлөлт оруулах үедээ дэвшилттэй заалтыг өөрчилсөн, шаардлагатай асуудлыг тусгаагүй зэрэг сул тал байгаа болон тогтвортой байдлын гэрээний хэрэгжилт, дуусвар болж буй хуулийн этгээдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, цаашид хэрхэх талаар тодорхой бодлогогүй байгаа бөгөөд Сангийн сайд нь гэрээлэгчийн хувьд салбарын яамд, төрийн захиргаа, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах ажиллагаа дутмаг байгааг цаашид анхаарч ажиллахыг тэмдэглэж, хөрөнгө оруулалтын амлалтыг бүс нутгийн хөгжлийг дэмжсэн байх гэсэн бодитой саналыг дэвшүүлсэн байна.

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Уул уурхайн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар 2.1

Дурдсан асуудал нь тус яамны бодлогын хүрээнд хамаарч байгаа боловч “Тогтвортой байдлын гэрээ”-ний хугацаа дуусаж байгаа ААН-үүдтэй холбогдолтой тул зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй юм.

Иймд зөвлөмжид өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Сангийн сайдад:

- Одоо хэрэгжиж буй ТБГ-нүүдэд холбогдох байгууллагуудтай хамтран дүн шинжилгээ хийж, нэмж тусгах шаардлагатай асуудлуудыг тодорхойлон гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,
- Гэрээний хугацаа нь дуусаж байгаа ААН-ийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор үнэлгээ өгч, үр дүнг олон нийтэд мэдээлэх,
- Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын татвар бий болгох асуудлыг судалж, санал боловсруулан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,

Уул уурхайн болон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд нарт:

- ТБГ-тэй ажиллаж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах,

Уул уурхайн сайдад:

- Төмөртийн овооны цайрын ордын нөөцийг шинэчлэн бүртгэх, нөөцөд бүртгэгдсэн эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдагч баялгийг үнэлэх, төмрийн хүдрийг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар холбогдох арга хэмжээ авах,
- Бороогийн алтны ордыг цаашид иж бүрнээр ашиглах эсэхийг судалж шийдвэрлэн, ил уурхайн нөхөн сэргээлтийг бүрэн хийлгүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 178

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Тогтвортой байдлын гэрээний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн яам, Уул уурхайн яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд хүргүүлсүгэй.

Гурав. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, дүнг 2014 оны 3 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Уул, уурхайн сайд Д.Ганхуяг, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун нарт зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал (Б.Баттуяа)-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

070499